

## МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2012 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр хуралдаж Монголбанкны гадаад активын байршил, арилжааны үйл ажиллагаа, Монголбанк болон арилжааны банкуудад мөрдөж буй хууль, эрх зүйн актыг боловсронгуй болгох ажлын үр дүн, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хуулийн дагуу хийж байгаа ажлын явц зэрэг асуудлыг хэлэлцэж тодорхой шийдвэрүүдийг гарган Монголбанкны удирдлагад зөвлөмж хүргүүлсэн байна. Мөн Хяналтын зөвлөлийн 2013 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

**1.** Гадаад валютын улсын нөөц 2012 оны эхний хагас жилийн дүнгээр 2,903.19 сая ам.долларт хүрч, импортын 19.79 долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд хүрсэн байна. Мөн оны 3 дугаар улирлын байдлаар 2,857.7 сая ам.доллар байгаа нь оны эхнийхээс нэмэгдсэн ч эхний хагас жилийнхээс буурсан байна.

Монголбанкны гадаад активын байршил, бүтэц, лимитийг Хөрөнгө оруулалтын хорооноос боловсруулсан саналыг үндэслэн тогтоож Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулан мөрдөж ажиллажээ.

Монголбанк валютын нөөцийг удирдаж гадаад активыг байршуулахдаа зохих хууль тогтоомж, эрх зүйн актыг баримтлан ажиллаж, валютын нөөцийн удирдлага нь Төв банкинд тавигдах үндсэн шаардлага болох найдвартай байх, төлбөр түргэн гүйцэтгэх шаардлагыг хангаж байна гэж Хяналтын зөвлөл үзжээ.

Хяналтын зөвлөл Төв банкны гадаад активын байршлын асуудлыг Монголбанкны санхүүгийн тайлан аудитын байгууллагаар баталгаажих явцад авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

**2.** Банкнаас гаргасан эрх зүйн баримт бичиг нь хууль, эрх зүйн актад нийцэж байгаад Хуулийн хэлтэс (хуучин нэрээр) хяналт тавьж, Монголбанкны эрх зүйн актын бүртгэлд бүртгэх, хадгалах, нэгдсэн бүртгэлийн сангаас мэдээлэл лавлагаа өгөх үйл ажиллагааны хүрээнд 1997-2012 онд 2910 эрх зүйн баримт бичгийг хянан бүртгэж, 43 эрх зүйн баримт бичгийг зөрчилтэй тул буцаажээ.

Монголбанкны Хууль, эрх зүйн болон Хяналт шалгалтын газар нь 2010-2012 онд Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль зэрэг хуулийг батлуулсны зэрэгцээ хэд хэдэн дүрэм, журмыг шинээр батлан мөрдүүлж эрх зүйн актуудад 2010-2012 онд 14 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж 31 хууль, эрх зүйн актын төсөлд санал өгчээ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 1991-2011 оны тушаалын кодификаци хийж, мэдээллийн нэгдсэн санг бий болгосон байна.

Монголбанк болон арилжааны банкуудад мөрдөж буй хууль, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох талаар хийсэн ажилд ахиц дэвшил гарч байна гэж Хяналтын зөвлөлөөс тэмдэглэсэн байна.

Банкны холбогдох хууль, эрх зүйн актыг шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах бүрт хууль тогтоомжид нийцэж байгаад Хууль, эрх зүйн газраас хянаж, санал дүгнэлт өгч байх, хууль, эрх зүйн бусад актыг олон нийтэд сурталчилан таниулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж болгосон байна.

3. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандарт, зөвлөмжид заасан шаардлагад нийцүүлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бий болгох үндэс суурийг тавьжээ. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Санхүүгийн мэдээллийн алба нь хуулийн хүрээнд арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хамруулан, тэдгээрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, бэлэн, бэлэн бус мөнгөний болон сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэх, харилцагчийн мэдээллийг хадгалах тогтолцоо бүрдүүлэх, дотоод хяналтыг бий болгохтой холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал, маягтыг батлуулж мөрдүүлэх, сургалт, сурталчилгаа хийх, олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллажээ.

Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг гадаад орны болон олон улсын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох боломжтой болж, зарим орны санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурж, Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн шинжээчээр томилогдож ажилласан байна.

СМА нь хуульд заасан чиг үүрэг, мэдээлэл авах хүрээг бүрэн хамарч ажиллах, зохицуулах харилцааг хамруулан гаргах зарим журам, зааврыг боловсруулж мөрдүүлэх шаардлагатай байна гэж Хяналтын зөвлөл үзсэн байна.

Монголбанкны СМА-аас хийж байгаа ажлын явцтай танилцаад Монголбанкны удирдлагад дараах зөвлөмжийг хүргүүлжээ. Үүнд:

- СМА-ыг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуульд заасан хүрээг бүрэн хамруулж ажиллуулах, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэл авах асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

- СМА-ны үйл ажиллагааны статистик, үр дүнгийн тайланг хагас жил тутам гаргуулж, бие даасан аудитын шалгалтыг тогтмол оруулж байх хэлбэрээр хариуцлага тооцож ажиллах;

- СМА-ны бие даасан үйл ажиллагааг хангахын зэрэгцээ төсөв болон хүний нөөцийг бэхжүүлэх болон уг албыг бэхжүүлэн чадавхжуулах хүрээнд төсөл, хөтөлбөр боловсруулах, олон улсын байгууллага, хандивлагч орнуудад санал тавих боломжийг судалж үзэх;

- Хуульд заасан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсын жагсаалтыг” батлах, “Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх журмын үлгэрчилсэн загвар батлах”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж холбогдох этгээдэд хүргэх” аргачлалыг боловсруулж мөрдүүлэх;

- Монголбанк нь Монгол Улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн тогтолцоог бий болгох, түүний

хөтөлбөр, баримт бичгийг боловсруулах, хяналт тавих асуудлыг Засгийн газрын холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлэх зэрэг болно.

## МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ